



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 4/170

Өмнөдэлгэр сум


Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.3, 19-20 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Тус сумын Хэнтий багийн “Янзаганы даваа” гэх газарт нутаглаж буй малчин Б.Мөнхбаярын суурьт Листерииоз өвчин оношлогдож 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хязгаарлалтын цээрийн дэглэм тогтоон, голомтод үзлэг, халдваргүйтгэл хийж ажилласны дүнд өвчин дахин илрээгүй тул хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Хязгаарлалтын дэглэмийг цуцалсантай холбогдуулан халдварт өвчний талаарх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол хийж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (С.Гантогоо), Хэнтий багийн Засаг дарга (А.Баянмөнх) нарт даалгасугай.

3. Эцсийн ариутгал халдваргүйтгэлийг чанартай зохион байгуулахыг “Хэйлти анимал стронг” мал эмнэлэгт, Листерииоз өвчинтэй тэмцэх арга хэмжээний нэгдсэн тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасагт тус тус үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР